БАТЛАВ:
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА П.ЛХАГВАЖАВ

2024 ОНЫ ... ДУГААР САРЫН ... НЫ ӨДӨР

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМАНД ШИНЭЭР БАРИГДАХ 35/10кВ-ЫН ДЭД СТАНЦЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР**

2024.10.31 №ЗД-2024/...103... Мөрөн сум

| | | |
|---|---|---|
| 1 | Зураг, төсөв зохиох үндэслэл | - Хөвсгөл аймгийн “Хөгжсөн Хөвсгөл” 2016-2030 он хөтөлбөр<br>- Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр |
| 2 | Барилга байгууламжийн нэр байршил | Хөвсгөл аймаг, Мөрөн сум<br>110/35/6кВ Мөрөн дэд станцын 35кВ-ын ил хуваарилах байгууламжаас гарсан 35кВ-ын 2 хэлхээт Хатгал, Арбулаг цахилгаан дамжуулах агаарын шугамын 19-р тулгуураас салбарлалт авч шинээр баригдах 35/10кВ-ын дэд станцын 35кВ-ын ил хуваарилах байгууламжаар оруулж гаргасан схемээр тэжээх |
| 3 | Объектын бүрэлдэхүүн, хүчин чадал (Шугам, дэд станц, хувиарлах байгууламж, жижүүрийн байр, шугамын оруулга, гаргалга, шугамын урт, хэлхээний тоо, хүчдэл тус бүрээр бичнэ ) | - Сумдын цахилгаан хангамжийн ЦЭХ-ний хүчдэлийн уналтыг зогсоож, хүчдлийн чанарыг нэмэгдүүлэх, өсөн нэмэгдэж байгаа ЦЭХ-ний хэрэглээ, найдвартай ажиллагааг хангах<br>- 35кВ-ын хоёр оролттой байх<br>- 35/10кВ-ын 2*2500кВА-ийн 2 трансформатор<br>- Транформаторуудын оруулга бүрт цэнэг шавхагч суурилуулах<br>- 35кВ-ын ИХБ-д 2 ороомогт хүчдэлийн трансформатор суурилуулах<br>- Трансформаторын чадалд тохирсон 35кВ, 10кВ-ын шинийн утас, шинийн портальтусгаарлах элемент<br>- Трансформаторуудын механик ачаалалд тохирсон суурьтай байх<br>- 35кВ-ын гаргалгаа тус бүр болон трансформаторуудын 2 оруулга дээр IEC стандартын шаардлага хангасан вакум таслуур, цахилгаан соронзон хоригтой хуурай салгуур тавих<br>- 35кВ-ын ИХБ –ын тоноглол 10кВ-ын ХХБ-ын тоног төхөөрөмжийн суурилуулалт болон газардуулгыг техник ашиглалтын дүрмийн шаардлагад нийцүүлэн хийх.<br>- 19мх8м хэмжээтэй барилга бүхий 10кВ хаалттай хуваарилах байгууламж<br>- 10кВ-ын 2 секцтэй секц бүрт ДХТ, ХТ суурилагдсан секц холбогчийн таслуур салгуур бүхий байх<br>- Гаргалгааны цахилгаан дамжуулах агаарын шугам 4км<br>- Кабель шугамын туннель нь тоноглолд засвар үйлчилгээ хийх, ажил гүйцэтгэх бүрэн боломжтой норм стандартын шаардлага хангасан байх |

| | | |
|---|---|---|
| | | - Кабель шугамын туннелиэс секц тус бүрээс КШ гарах сувагтай байх<br>- 10кВ-ын Ячейк нь олон улсын IEC-61850 цуврал стандартын шаардлага хангасан нумын болон газардуулгын хамгаалалтын функц агуулсан микропроцессорын реле хамгаалалт сонгож суурилуулах<br>- Олон Улсын IEC62056 цуврал стандартын шаардлагыг хангасан, Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын тохирлын гэрчилгээ бүхий, ашиглагч байгууллагын техникийн шаардлагыг хангасан ухаалаг тоолуур сонгох<br>- Техникийн нөхцөлд дурдсан бусад шаардлагуудыг зураг төсөлд тусгах<br>- Дэд станцад суурилагдах тоног төхөөрөмж нь Монгол орны цаг уурын нөхцөл, далайн түвшний 1000м-ээс дээш өндөрлөг, олон улсын IEC стандартын шаардлагыг хангасан орчин үеийн дэвшилтэт технологитой байх<br>- Тооцоогоор сонгогдсон тоног төхөөрөмжүүд нь Монгол Улсын болон Олон Улсын Цахилгаан техникийн хорооноос гаргасан стандартуудыг хангасан байх<br>- Дэд станцын газардуулга, аянга хамгаалалтын зон, гэрэлтүүлэг нь техник ашиглалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан байх<br>**Барилгын норм, дүрэм :**<br>• Цахилгаан техникийн ажил БНбД 3.05.06-90<br>• Автоматжуулалтын систем БНбД 3.05.07-90<br>• Цахилгааны ажил БНбД 81-70-05<br>• Цахилгаан байгууламжийн дүрэм БД43-101-03*12<br>• Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар БД43-103-08<br>• Монгол Улсын цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм БД43-101-03<br>• "Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНбД 21-01-02<br>• Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм /БНбД 3.01-06-90<br>• Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, -зөвшилцөх, магадлал хийх дүрэм<br>• Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 4244:1994<br>Бусад холбогдох норм, дүрэм |
| 4 | Инженерийн хангамж. (байгууламжийн техникийн нөхцлөөр тавигдах шаардлагууд) | Техникийн тодорхойлолтод дурдсан инженерийн хангамжтай. Хангагч байгууллагаас техникийн нөхцөл авсан байна. |
| 5 | Цаашид өргөтгөх эсэх. (Өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэлт, техникийн тодорхойлолтыг тоноглол тус бүрээр) | Цаашид өргөтгөх боломжтойгоор зай талбайг тооцож зураг төсөлд тусгах |

| | | |
|---|---|---|
| 6 | Зураг төслийн баримт боловсруулах үе шат, хугацаа | • Барилгын ажлын зураг нэг үе шаттай байна. Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно. |
| 7 | Барих хугацаа | • 2025 он |
| 8 | Зураг төслийн байгууллага | "Эрчим хүчний барилга угсралтын тусгай зөвшөөрөл" авсан, эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх |
| 9 | Хөрөнгө оруулагч (захиалагч ) байгууллага | Улсын төсөв (захиалагч Хөвсгөл эрчим хүч ХХК) |
| 10 | Онцгой нөхцөл | ✓ Зураг төсөл боловсруулахдаа газар дээр нь хэмжилт хийж захиалагч болон мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөж ажиллах.<br>✓ Зургийн үнэ болон техникийн нөхцөлүүдийн үнийг төсөвт тусгах<br>✓ Зураг төслийг Монгол улсын Цахилгаан байгууламжийн дүрэм, Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн механик ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу гүйцэтгэх<br>✓ Зураг төслийг экспертед оруулахын өмнө ашиглагч байгууллага болон холбогдох газруудаар хянуулж, зөвшөөрөл авсан байх<br>✓ Хүчний болон гэрэлтүүлгийн самбарт давтан газардуулга, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авах |
| 11 | Галын аюулгүй байдлын нөхцөл | "Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНБД 21-01-02, "Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм" БНБД 21-02-02, "Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгсэл" БНБД 21-04-05 норм дүрмүүдээс холбогдох заалтуудыг авч төлөвлөнө. |
| 12 | Эдийн засгийн тооцоо , (төсөв) | БНбД 81-95-12 төсөв зохиох дүрмийн дагуу төсвийн ESTIMATOR-PRO программ болон түүнтэй ижил эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцсон байна. |

**ХЯНАСАН:**

АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ: / Д.САНДАГДОРЖ /

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН: /Э.АЗЗАЯА/

**ЗУРГИЙН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:**

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН: /Б.БААСАНЖАВ/